



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/684

Мөрөн сум

Барилга, байгууламж ашиглалтад
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгыг хүлээж авах ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал

(Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын Барилга хот
байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

А.Баттүшиг

(Хатгал тосгоны захирагч)

Э.Аззаяа

(Аймгийн ерөнхий архитектор)

Г.Ням-Эрдэнэ

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын
тасгийн дарга)

Д.Аюушжав

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Б.Гал-Эрдэнэ

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Мэдээлэл харилцаа холбооны хяналтын
улсын байцаагч)

Д.Мягмарсүрэн

(Аймгийн Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын Барилга техник
хяналтын улсын байцаагч)

Л.Бямбасүрэн

(Аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас
хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч)

Г.Даваадорж

(“Хөвсгөл эрчим хүч” ХХК-ийн Ерөнхий
инженер)

Б.Цэнддэлгэр

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын ахлах
мэргэжилтэн)

Ц.Бямбатөр

(Аймгийн Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын геодезийн мэргэжилтэн)

6712012088

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Д.Оюун-Эрдэнэ

(“Итгэлт чандмань” ХХК-ийн инженер)

Захиалагчийн хяналтын байгууллагын төлөөлөл:

Ж.Ганзоригт

(“Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв”-ийн хяналтын ерөнхий инженер)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Н.Хадбаатар

(“ХБС” ХХК-ийн захирал)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Г.Нарангэрэл

(Хатгал тосгоны Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Комиссын нарийн бичгийн дарга:

Б.Баасанжав

(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2.Барилга байгууламжийн ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3.Барилга байгууламжийн ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Б.Баасанжав)-д үүрэг болгосугай.

4.Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Гансүх)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ТӨМӨРБААТАР